



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/87

Бсөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол туургатны харвуул наадам Мөсний сурын "Улсын аварга шалгаруулах" тэмцээнд оролцох аймгийн Үндэсний сурын холбооны баг тамирчдын замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Үр дүнг тайлагнахыг аймгийн Үндэсний сурын холбоо (Б.Лхагва-Очир)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\My document

8200010327

